



НЧХААГ
Улаанбаатар

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/181

Улаанбаатар х/д


Зэрэг дэв, түүний
нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 1995 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 73 дугаар, 2000 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” 20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг нэгдүгээр хавсралтаар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг гуравдугаар хавсралтаар, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус олгосугай.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, түүний харьяа хэлтсүүдийн дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг даргын 2015 оны
03 дугаар сарын 12-ны өдрийн А/181 дүгээр
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

Бүртгэлийн дугаар 26
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажлын газрын үсэг
.....
2015 оны 03 сарын 12-ны өдөр

Төрийн захиргааны албан хаагчдад олгосон
албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл

№	Овог нэр	Албан тушаал		санал	
		Нэр	Ангилал зэрэглэл	Зэрэг дэв	Нэмэгдэл /хувь/
Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар					
1	Дондогцэрэн Мягмарсүрэн	Хэлтсийн дарга	ТЗ-8	Ахлах түшмэл дөтгөөр зэрэг	20
2	Цэрэнлхам Төмөртулга	Хэлтсийн дарга	ТЗ-8	Ахлах түшмэл дөтгөөр зэрэг	20
3	Цэрэндаш Баярмаа	Мэргэжилтэн	ТЗ-5	Дэс түшмэл дэд зэрэг	18
4	Пүрэвсүрэн Эрдэнэсүрэн	Мэргэжилтэн	ТЗ-5	Дэс түшмэл дөтгөөр зэрэг	15